

ХҮНИЙ НӨӨЦИЙН ТАЙЛАН

/2022 оны жилийн эцсийн байдлаар/

Сүхбаатар сум

Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газрын даргын 2019 оны 08 дугаар сарын 08-ны өдрийн “Аймгуудын Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын зохион байгуулалтын бүтэц орон тоог батлах тухай” Б/123 дугаар тушаалаар Сэлэнгэ аймгийн Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газар нь Газрын удирдлагын хэлтэс, Барилга, хот байгуулалтын хэлтэс гэсэн 2 хэлтэстэй нийт 40 албан хаагчийн бүрэлдэхүүнтэй байхаар батлагдсан.

Мөн сумдын Засаг дарга нарын хүсэлт болон газрын нэгж талбар, хүн амын тоог тус тус харгалзан ГЗБГЗЗГ-ын даргын 2022 оны Б/59 тоот тушаалаар Баянгол, Мандал, Сайхан, Цагааннуур, Шаамар сумдын газрын даамлын орон тоог тус бүр нэгээр нэмэгдүүлсэн.

Тайлант оны жилийн эцсийн байдлаар тус газар нь 40 ажилтантай үйл ажиллагаагаа явуулж байна.

Үүнээс төрийн захиргааны албан тушаалд 34, төрийн үйлчилгээний албан тушаалд 4, хөдөлмөрийн гэрээ байгуулан ажиллаж буй 4 албан хаагч байна.



График 1. Албан хаагчдын ангилал

Хүний нөөцийн удирдлагыг хэрэгжүүлэх чиглэлээр:

Тайлант хугацаанд байгууллагын хүний нөөцийн бодлогыг хэрэгжүүлэхтэй холбоотой газрын даргын 35 тушаалын эрх зүйн актын төслийг боловсруулан хянаж, батлагдсан тушаалын дагуу “Төрийн албаны хүний нөөцийн нэгдсэн системд” мэдээллийг тухай бүр шинэчлэн, тушаалын хэрэгжилтийг ханган ажиллаж байна.

Хөдөлмөрийн гэрээ байгуулан ажиллуулах тухай Газрын даргын 4 удаагийн тушаалын дагуу шинээр томилогдон ажиллаж буй албан хаагчидтай байгуулах хөдөлмөрийн гэрээний төслийг боловсруулан хянаж, албажуулах ажлыг зохион байгуулав.

Тайлант онд төрийн албаны тухай хуульд заасан сул орон тоог нөхөх дарааллын дагуу нөөцөд бүртгэгдсэн 4 иргэний хүсэлтийг харгалзан, сумдын Засаг дарга нартай харилцан тохиролцсоны дагуу “Хөдөлмөрийн гэрээ” байгуулан ажиллуулж байна.


газрын даамлын орон тоонд ажиллуулах, төрийн албаны нөөцөд бүртгэгдсэн, тухайн албан тушаалд тавигдах шаардлагыг хангаж буй иргэдийн мэдээллийг авах зорилгоор аймгийн Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлд 2022.05.23-ны өдрийн 01/105 тоот албан бичгийг, мөн сумдын хөдөлмөр эрхлэлтийн албанд бүртгэлтэй, албан тушаалын шаардлагыг хангаж буй иргэний мэдээллийг гаргуулан, хамтран ажиллах тухай 2022.06.20-ны өдрийн 01/64, 01/65, 01/66, 01/67, 01/68 тоот албан бичгүүдийг Баянгол, Мандал, Сайхан, Цагааннуур сумдын Засаг дарга, Шаамар сумын Дулаанхаан тосгоны захирагч нарт тус тус хүргүүлсэн.

Мөн тухайн албан тушаалд ажиллах хүсэлт гаргасан 2 иргэний хүсэлтийг харгалзан, сумдын Засаг дарга нартай харилцан зөвшилцөж, Баянгол, Сайхан сумдын газрын даамлын албан тушаалд тус тус хөдөлмөрийн гэрээ байгуулан ажиллуулж байна.

6. Төрийн албаны тухай хуульд тусгагдсан “Төрийн жинхэнэ албан тушаалд сонгон шалгаруулж томилох журам”-ын дагуу 3 албан хаагчийн шилжин ажиллах тухай хүсэлтийг үндэслэн Газрын даргын 2022 оны Б/11, Б/25, Б/29 дүгээр тушаалуудаар 3 албан тушаалын сул орон тоонд шилжүүлэн ажиллуулж байна.

7. “Төрийн албаны тухай хууль”, “Төрийн жинхэнэ албан хаагчийг өөр албан тушаалд шилжүүлэх, сэлгэн ажиллуулах журам” болон албан хаагчийн хүсэлтийн дагуу бусад байгууллагын удирдлагатай харилцан тохиролцож, 2 албан хаагчийг Газрын даргын 2022 оны Б/26, Б/28 тоот тушаалуудаар бусад байгууллагад шилжүүлсэн.

8. Газрын даргын 2022 оны “Ажлаас чөлөөлөх тухай”-2, “Хүүхэд асрах чөлөө олгох тухай”-1, “Хөдөлмөрийн гэрээ цуцлах тухай”-2, “Ажилд томилох тухай”-5, “Албан үүргийг түр орлон гүйцэтгүүлэх тухай”-3, “Хөдөлмөрийн гэрээ байгуулан ажиллуулах тухай”-4, “Шилжүүлэх болон шилжүүлэн ажиллуулах тухай”-5 удаагийн тушаалуудаар байгуулагдсан ажил хүлээлцэх ажлын хэсгийн бүрэлдэхүүн Сүхбаатар, Орхонтуул, Түшиг, Мандал, Хүдэр, Сайхан, Зүүнбүрэн, Ерөө /Бугант тосгон/, Алтанбулаг сумдад ажиллан ажил хүлээлцэх, хүлээлгэн өгөх ажлыг акт үйлдэн хийж гүйцэтгэв.



Төрийн албан хаагчдын ажлын гүйцэтгэл, үр дүн, ур чадвар, санал санаачилгыг харгалзан цалин хөлс, урамшууллын тогтолцоог бүрдүүлэх зорилтын хүрээнд

“Төрийн албаны тухай хууль”, “Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчид төрийн алба хаасан хугацааны нэмэгдэл олгох журам”-ын хэрэгжилтийг хангах зорилгоор тус нэмэгдлийг Газрын даргын 2022 оны “Албан тушаалын ангилал, зэрэглэлийг өөрчилж, цалингийн хэмжээг шинэчлэн тогтоох тухай” А/02

тушаалаар төрийн албанд арван нэгэн жил ажилласан **1** албан хаагчид 10 хувиар тооцон нэмэгдүүлэн олгож байна.

Ингэснээр төрийн байгууллагад 6-10 жил ажилласан **9** албан хаагчид 5 хувийн, 11-15 жил ажилласан **9** албан хаагчид 10 хувийн, 16-20 жил ажилласан **3** албан хаагчид 15 хувийн, 21-25 жил ажилласан **3** албан хаагчид 20 хувийн нэмэгдлийг тус тус олгож байна.




График 2. Төрийн албан хаасан хугацааны нэмэгдэл олгож буй байдал.

“Төрийн захиргааны албан тушаалын зэрэг дэв, түүний нэмэгдэл олгох журам”-ын дагуу төрийн албанд болон тухайн албан тушаалын ангилалд ажилласан хугацаа, үйл ажиллагааны үр дүн, мэргэшлийн түвшинг үндэслэн нийт **21** албан хаагчид зэрэг дэв олгуулах саналыг Төрийн албаны зөвлөлийн Сэлэнгэ аймаг дахь салбар зөвлөлд хүргүүлж, Сэлэнгэ аймгийн Засаг даргын 2022 оны А/95 тоот захирамжаар **15** албан хаагчид зэрэг дэвийг ахиулан, **6** албан хаагчид зэрэг дэвийг шинээр тус тус олгуулж ажилласан.





График 3. Төрийн захиргааны албан хаагчдын зэрэг дэв.




Сэлэнгэ аймгийн Засаг даргын
2022 оны 03-р сарын 28-ны өдрийн А/95
захиралмжийн б-р үндэслэлээр

АЙМГИЙН НУТГИЙН ЗАХИРГААНЫ БАЙГУУЛАГДАН ТӨРИЙН ЗАХИРГААНЫ АЛБАН ХААГЧИД
ЗЭРЭГ ДЭВ ШИНЭЭР БОЛОН АХИУЛАН ОЛГОСОН АЛБАН ХААГЧИД

Д/д	Овог нэр	Албан тушаал	Амтлан зэрэглэл	Төрийн алба хаасан үргэлжлэл	Нийлүүлбэл зохих							Нийт үнэмлэг	Урьд авч байсан зэрэг дээ	Шинээр олгох зэрэг дээ
					Тусгай албан тушаалд амжилсан үргэлжлэл	Гүйцэтгэлийн зорилт	Арга хэмжээний баримт, үндэслэл	Хөдөлмөрийн үнэмлэг	Мэдэгдэж, чадвартай ажилласан үнэмлэг	Мэдэгдэж, чадвартай ажилласан үнэмлэг	Нийт үнэмлэг			
Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газар														
1	Базаргард Сэрүлтөгс	Газрын дарга	T3-10	12.11	5.4	65.4	15	13	93.4	Маш сайн	Аймгийн Засаг даргын 2019 оны 03 дугаар сарын 22-ны А/95 захиралмжаар олгох түшмэлийн дотоод зэрэг	Олгох түшмэлийн гутгаар		
2	Бадамсамбуу Мөнхсайх	Газрын удирдлагын хэлтсийн дарга	T3-7	14.5	6.9	56	13	15	84	Сайн	Аймгийн Засаг даргын 2019 оны 03 дугаар сарын 22-ны А/95 захиралмжаар олгох түшмэлийн дотоод зэрэг	Дэс түшмэлийн дээд зэрэг		
3	Чулунбат Доржнямгар	Барилга, хот байгуулалтын хэлтсийн дарга	T3-7	13.8	10.3	57.8	12.7	15	85.5	Сайн	Аймгийн Засаг даргын 2019 оны 03 дугаар сарын 22-ны А/95 захиралмжаар олгох түшмэлийн дотоод зэрэг	Дэс түшмэлийн дээд зэрэг		
4	Онц Баярхүү	Барилгын асуудал хариуцсан ахлах мэдээлэлтэн	T3-6	12.1	4.3	62	12.5	10.5	85	Сайн	Аймгийн Засаг даргын 2019 оны 03 дугаар сарын 22-ны А/95 захиралмжаар олгох түшмэлийн дотоод зэрэг	Дэс түшмэлийн дээд зэрэг		

Мөн Монгол улсын Засгийн 2022 оны “Тогтоол, тогтоолын хавсралтад өөрчлөлт оруулах тухай” 192 дугаар тогтоолын дагуу төрийн үйлчилгээний 1 албан хаагчийн цалинг 2022 оны 05 дугаар сарын 11-ний өдрөөс эхлэн нэмэгдүүлэн олгож байна.



Албан хаагчийн ажлын гүйцэтгэл, үр дүн, мэргэшлийн түвшинг харгалзан Газрын даргын 2022 оны “Цалингийн шатлал ахиулах тухай” Б/01 дүгээр тушаалаар 12 албан хаагчийн цалингийн шатлалыг нэмэгдүүлж Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 472 дугаар тогтоолд заасан хэмжээгээр албан хаагчдын цалин урамшууллыг олгож байна.

График 4. Албан хаагчдын цалингийн шатлал.

Албан хаагчдын нийгмийн асуудлыг шийдвэрлэж тусламж, тэтгэмж, дэмжлэг, нөхөн олговор олгох зорилтын хүрээнд

1. “Хөдөлмөрийн тухай хууль”, “Ээлжийн амралт олгох, ээлжийн амралтын цалин тооцох журам” болон байгууллагын хөдөлмөрийн дотоод журамд тус тус заасны дагуу албан хаагчдын саналыг үндэслэн, “Албан хаагчдын 2022 оны ээлжийн амралтын хуваарь”-ийг эхний улиралд багтаан баталж, хуваарийн дагуу албан хаагчдад ээлжийн амралтыг олгон ажилласан.

2. Байгууллагын “Хөдөлмөрийн дотоод журам”-д заасан дараах тусламж, тэтгэмжийг олгосон. Үүнд:

- ✓ Албан хаагчдын нийгмийн баталгааг хангах үүднээс албан хаагчийн ахуй амьдрал, ар гэрт гачигдал тохиолдвол буцалтгүй тусламж олгох харилцааг байгууллагын хөдөлмөрийн дотоод журамд тусган шийдвэрлэж байгаа бөгөөд тайлант хугацаанд тус журмын 7.4.1.3-т заасны дагуу Газрын даргын 2022 оны

Б/08, Б/13, Б/18, Б/38 тоот тушаалуудаар 4 албан хаагчид тус тус 250,000 төгрөгийн тусламж,

- ✓ Ахмад настны тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1 дэх заалт, байгууллагын дотоод журмын 7.5.2 / *Байгууллагаас тэтгэвэрт гарсан өндөр настнуудад цагаан сар, ахмадын баярыг тохиолдуулан хүндэтгэл үзүүлнэ*/ дахь заалтын дагуу тус байгууллагаас өндөр насны тэтгэвэрт гарсан 8 ахмад ажилтанд цагаан сарын баяр, ахмадын баярыг тохиолдуулан Газрын даргын 2022 оны Б/02, А/11 тоот тушаалуудаар тус бүр тэтгэмж олгож, хүндэтгэл үзүүлсэн.
- ✓ Шинээр хүүхэдтэй болсон 1 албан хаагчид “Хөдөлмөрийн дотоод журам”-ын 7.5.3-т заасны дагуу Газрын даргын 2022 оны Б/12 тоот тушаалаар 100,000 төгрөгийн тэтгэмж олгосон.
- ✓ Албан хаагчдын нийгмийн баталгааг хангахад дэмжлэг үзүүлэх зорилгоор “Хөдөлмөрийн дотоод журам”-ын 7.5.7-д заасны дагуу гэрт болон төвлөрсөн халаалтын системд холбогдоогүй байранд амьдардаг 5 албан хаагчид Газрын даргын 2022 оны Б/39 тоот тушаалаар түлээ нүүрсний тэтгэмж олгосон.

Албан хаагчдыг чадахжуулах чиглэлээр

Салбарын хэмжээнд зохион байгуулах зөвлөгөөн, хэлэлцүүлэг, сургалтын 2022 оны 17 арга хэмжээ бүхий төлөвлөгөөний дагуу ГЗБГЗЗГ-аас зохион байгуулж буй сургалтуудад албан хаагчид тогтмол хамрагдан тус төлөвлөгөөний эхний хагас жилийн хэрэгжилтийн тайланг ГЗБГЗЗГ-т хүргүүлсэн. Мөн тус төлөвлөгөөний хэрэгжилтийг жилийн эцсийн байдлаар гарган ГЗБГЗЗГ-т хүргүүлэхээр бэлтгэн ажиллаж байна.

✚ Сэлэнгэ аймгийн хэмжээнд тариалан болон өвөлжөө, хаваржааны газарт бүртгэл тооллого хийх ба газар ашиглалтын байдлыг зайнаас тандан судлалын технологид суурилсан аргачлалаар зохион байгуулах талаар сумдын газрын даамлуудад мэдлэг олгох, Аймгийн Засаг даргын 2022 оны А/453 тоот захирамжийн хэрэгжилтийг хангахад нэгдсэн удирдлагаар хангах зорилго бүхий сургалтын 2022.10.26-2022.10.27-ны өдрүүдэд Сүхбаатар суманд зохион байгууллаа.



Уг сургалтаар сумдын газрын даамлуудыг мэргэшүүлэх зорилгоор аймгийн ГХБХБГ-ын холбогдох мэргэжилтнүүд хариуцсан асуудлуудын дараах мэдээллүүдийг хүргэж, мэргэжил арга зүйн зөвлөгөөгөөр хангаж ажиллав. Үүнд:

- ✓ Газар зохион байгуулалтын төлөвлөгөө боловсруулах болон түүний хэрэгжилтэд анхаарах асуудлууд
- ✓ Зах зээлийн үнийн мэдээг үнэлгээний программд оруулах
- ✓ Газрын кадастрын мэдээллийн санд бүртгэгдсэн зөрчилтэй нэгж талбаруудын мэдээллийг засварлах
- ✓ Газар эзэмших, ашиглах эрхийн гэрчилгээ олгох журмын зарим анхаарах зохицуулалтууд
- ✓ Геопорталд геодезийн цэг тэмдэгтийн мэдээллийг засварлах, баяжуулах болон газар зүйн нэрийн тодруулалт мэдээллийн санг хөтлөх анхаарах асуудлууд
- ✓ Барилгын ажлыг эхлүүлэх, үргэлжлүүлэх зөвшөөрөл олгохтой холбоотой цахим системийн танилцуулга
- ✓ Төрийн жинхэнэ албан хаагчийн гүйцэтгэлийн биелэлтэд анхаарах асуудлууд



✚ Мөн нийт албан хаагчдыг соён гэгээрүүлэх, тэдний хуулийн мэдлэгийг дээшлүүлэх зорилгоор Сэлэнгэ аймаг дахь Тагнуулын газрын ажилтан Б.Бүрэнжаргалаас “Төрийн болон албаны нууцын хадгалалт, хамгаалалт” сэдэвт сургалтыг, Хилийн цэргийн 0101 дүгээр ангийн Сэтгэл зүйн бэлтгэлийн албаны ахлах офицер Э.Наранзулаас “Хамт олны сэтгэл зүйн хүч” сэдэвт сургалтуудыг тус тус авч, хийт албан хаагчдын хамруулсан.



✚ НҮБ-ын Хөдөө аж ахуйн байгууллага “Хөдөө аж ахуйн менежмент, экосистемийн тогтвортой байдлыг хангах” (STREAM) төсөл болон азар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газартай хамтран албан хаагчдыг чадавхижуулах сургалтыг 2022.12.15-2022.12.16-ны өдрүүдэд зохин байгуулав. Сургалтаар:

- ✓ Газрын багц хуулийн төсөл
- ✓ Сэлэнгэ аймгийн Газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөө
- ✓ Сумын нутаг дэвсгэрийн ерөнхий төлөвлөгөө
- ✓ Тухайн жилийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөг газар зохион байгуулалт, хот төлөвлөлтийн нэгдсэн системд хэрхэн оруулах
- ✓ Бэлчээрийн газрын өөрчлөлтийг фотомониторингийн аргаар үнэлэх аргачлал, цаашид авах арга хэмжээ
- ✓ Зөрчилтэй нэгж талбарын зөрчлийг арилгах
- ✓ Газрын кадастрын мэдээллийн санг эрхлэхэд тулгарч буй бэрхшээл
- ✓ Газрын төлбөр, татвар ногдуулалт
- ✓ Газрын цахим биржийн систем талаар мэдээлэл хүргэлээ.




Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2003 оны 105 дугаар зарлиг, Сэлэнгэ аймгийн Засаг даргын 2022 оны “Үндэсний бичигтэн-2022-2024” хөдөлгөөнийг өрнүүлэх тухай” А/177 тоот захирамжийг тус тус хэрэгжүүлэх, “Монголын үндэсний бичиг үсгийн баярын өдөр”-ийг байгууллагын хэмжээнд тэмдэглэн өнгөрүүлэх, эх хэлээ эрхэмлэн, дээдлэх, бичиг соёлын дурсгалаа сэргээн санах зорилгоор “Үндэсний бичиг үсэг, өв соёлоо эрхэмлэгч байгууллага” аяныг 2022 оны 05 дугаар сарын 09-ний өдрөөс 05 дугаар сарын 11-ний өдрүүдэд зохион байгуулж, нийт албан хаагчдыг хамруулав.

Тус аяныг хэрэгжүүлэх зорилгоор дараах ажлуудыг зохион байгуулав. Үүнд:

1. Монгол бичгийн мэргэжлийн багштай хамтран байгууллагын албан хаагчдад **“Үндэсний бичиг үсэг, тусгаар тогтнолын баталгаа”** сэдэвт сургалтыг зохион байгуулж үндэсний бичгийн талаар ерөнхий ойлголтыг албан хаагчдад олгов.

Сургалтын үеэр албан хаагчдын үндэсний бичгийн талаарх ерөнхий мэдлэгийн түвшинг тогтоох зорилгоор сорил, тэмцээнүүдийг зохион байгуулж мөн байгууллагын зөв, цэвэр бичигтэн, тод түргэн уншигчийг тус тус шалгаруулав.



Гамшгийн аюулын тухай зарлан мэдээллийн дохиогоор ажиллах, газар хөдлөлтийн гамшгийн аюулаас урьдчилан сэргийлэх, таниулах өдрийг тэмдэглэн өнгөрүүлэх тухай аймгийн Засаг даргын 2022 оны А/93 тоот захирамж гарсантай холбогдуулан 03 дугаар сарын дөрөв дэх долоо хоногийн Пүрэв гарагийн 16:00 цагт гамшгийн аюулын тухай зарлан мэдээллийн дохиогоор ажиллаж аюулгүй газар шилжин байрших дадлага сургуулийг зохион байгуулах бэлэн байдлыг хангах талаар ирүүлсэн Онцгой байдлын зөвлөмжийн дагуу хийсэн бэлтгэл арга хэмжээ болон сургалтыг хийж гамшгаас хамгаалах төлөвлөгөөнд тодотгол хийлээ.




2. Мөн байгууллагын албан хаагчдын нэр, албан тушаалын нэрийг кирилл олон үндэсний бичгээр зэрэгцүүлэн бичих ажлыг зохион байгуулж, хаягийг байршуулав.



Байгууллагын “Эцэг эхийн зөвлөл”-өөс Хүүхэд хөгжил-хамгааллын жилийн хүрээнд 2022 оны 05 дугаар сарын 22-ны өдөр Сүхбаатар суманд үйл ажиллагаа явуулж буй “Тод смайл” шүдний хувийн эмнэлэгт байгууллагын 9 албан хаагчдын 24 хүүхдийн шүдийг урьдчилсан сэргийлэх үзлэгт хамруулж шүдний өвчлөлтэй байгаа хүүхдүүдийн аав ээж нарт зөвлөгөө өгч ажилласан.



Аймгийн Гэмт хэргээс урьдчилсан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөл, Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн газраас 2022 оны 05 дугаар сарын 24-ний өдөр зохион байгуулсан “Байгууллагын дэргэдэх эцэг эхийн зөвлөлийн анхдугаар зөвлөгөөнд байгууллагын эцэг эхийн зөвлөлийн 5 гишүүн хамрагдсан.



Монгол Улсын Шадар сайдын аймгийн Засаг даргатай байгуулсан гэрээний дагуу Гамшгаас хамгаалах иж бүрэн сургууль манай аймагт 06 дугаар сарын 03-05-ны өдрүүдэд зохион байгуулагдсан. Газрын даргын 2022 оны “Гамшгаас хамгаалах барилга, хот байгуулалтын албаны бүрэлдэхүүнийг батлах тухай” А/06 тоот тушаалаар албаны бүрэлдэхүүн болон ажиллах төлөвлөгөөг баталгаажуулж ажилласан.



Болзошгүй аюул, ослын нөхцөл байдлын үнэлгээ, шийдвэр гаргах, гамшгийн голомтод эрэн хайх, аврах, хор уршгийг арилгах, хүмүүнлэгийн тусламж үзүүлэх, хохирлын үнэлгээ хийх үеийн орон нутгийн удирдлагын үйл ажиллагааг авч хэрэгжүүлэхээр өгөгдсөн цагийн байдлын дагуу:

- Шаардлагатай мэргэжлийн албадуудыг тухайн газар нутгийн байр зүйн зургаар хангах
- Үер усны аманд буусан айл өрхийн судалгааг гаргах,
- Барилга, объектын хийц, загвар, бүтэц зохион байгуулалтын болон насжилтийн судалгааг гаргаж байр зүйн болон кадастрын зурганд тусгах,
- Жижүүрлэлт хөтлөх зорилгоор хот байгуулалтын байр зүйн зургаар мэргэжлийн албадуудыг хангах,
- Нүүлгэн шилжүүлэлтийг хийх маршрутыг зарлан мэдээллэх албанд хүргүүлэх
- Өвчний голомт, болон хөл хорио тогтоосон газрын хилийг кадастрын зураг дээр тэмдэглэж зурагжуулах ажлыг гүйцэтгэж ажиллалаа.



Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газрын дарга, Сэлэнгэ аймгийн Засаг дарга нарын хянаж баталгаажуулсан “Байгууллагын 2022 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө”-нд тусгагдсан “Сумдын газрын даамлуудын ажилд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх” ажлыг 2022.10.28-2022.11.11-ний өдрүүдэд зохион байгуулж, Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газрын даргын тушаалаар батлагдсан шалгуур үзүүлэлтүүдийн дагуу 17 сумдын газрын даамлын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ үнэлгээг хийх, газрын даамалд ирсэн өргөдөл, хүсэлт шийдвэрлэлтийн үйл явцад хяналт хийж шийдвэрлэгдэхгүй байгаа зарим асуудлын шалтгаан нөхцөлийг олж тодорхойлох, Засгийн газрын 2020 оны 218 дугаар тогтоолоор батлагдсан “Төрийн жинхэнэ албан хаагчийн ажлын гүйцэтгэл, үр дүн, мэргэшлийн түвшинг үнэлэх аргачлал”-ын маягт №TAX_01-ийн дагуу тухайн сумын газрын даамлын ажлын хандлага, ёс зүй, ур чадварын үнэлгээ иргэдээр үнэлүүлэх ажлыг тус тус зохион байгуулж ажиллалаа.